



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.03.12 № 3Г-1/07

танай _____-ны № _____-т

Хөгжлийн төлөвлөгөөний
гүйцэтгэлийг өргөн мэдүүлэх тухай

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайланг
Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000264000933



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026-03-09 № НХТ/752
танай _____-ны № _____-т

Тов тогтоолгох тухай

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайланг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт М. хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000065003459


МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“19.3.“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ж.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний гүйцэтгэлийн тайланг хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2026 оны 03 дугаар сарын 09-ны
өдрийн 0001/752 тоот албан бичгийн
хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2026**

Гарчиг	
Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, зорилго	3
Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ, арга зүй	3
Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн	3
3.1.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл	3
3.1.1.Тэргүүлэх чиглэлийн үр дүн	4
3.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	6
3.1.2.1.Эдийн засгийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	6
3.1.2.2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	8
3.1.2.3.Хүний хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	9
3.1.2.4.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн	11
3.1.3. Хөтөлбөрийн үр дүн	12
3.1.4.Төсөл, арга хэмжээний үр дүн	13
3.1.5.Санхүүжилтийн гүйцэтгэл:	15
3.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ	17
3.3.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээ шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ	18
Дөрөв. Дүгнэлт	19
4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд:	19
4.2. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:	19
4.3.Бодлого төлөвлөлтийн хүрээнд:	20

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 20

Улаанбаатар хот

“Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”, 2 дугаар хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”, 3 дугаар хавсралтаар “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”-ийг тус тус баталсан.

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, зорилго

Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд тэргүүлэх чиглэл, төсвийн ерөнхийлөн захирагч, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ тус бүрээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шийдвэр гаргах түвшинд мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэгч байгууллагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээний хамрах хүрээ, арга зүй


Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын 20 тэргүүлэх чиглэлийг 6 шалгуур үзүүлэлтээр, төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 үр дүнг 47 шалгуур үзүүлэлтээр, хөтөлбөрийн 63 үр дүнг 91 шалгуур үзүүлэлтээр, 328 төсөл, арга хэмжээг 375 шалгуур үзүүлэлтээр Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.1, 6.3, 6.4, 6.7 дахь хэсэгт заасан аргачлалын дагуу Улсын Их Хурлын харьяа байгууллага, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны байгууллагуудаас Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний цахим систем (new.unelgee.gov.mn)-ээр илгээсэн гүйцэтгэлийн тайлан, холбогдох нотлох баримтад үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Гурав.Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн

3.1.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлэх чиглэлийн үр дүн 48.5 хувь, төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ)-ийн үр дүн 59.7 хувь, хөтөлбөрийн үр дүн 57.1 хувь, нийт төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дунджаар 61.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

График 1.Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлийн хувь, оноор



Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэргүүлэх чиглэлийн үр дүн 0.2 хувиар, хөтөлбөрийн үр дүн 0.14 хувиар, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 3.8 хувиар тус тус өссөн бол, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж төсөв танагдсантай голчлон холбоотой байна.

3.1.1.Тэргүүлэх чиглэлийн үр дүн

Монгол Улсын 2025 онд баримтлах 4 бодлогын тэргүүлэх чиглэлийн үр дүнг хэмжих хяналт-шинжилгээ, үнэлгээний 6 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тайлант хугацааны зорилтот түвшинтэй харьцуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд мэдээллийн эх сурвалж гараагүй 2 шалгуур үзүүлэлтээс бусад 4 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд тэргүүлэх чиглэлийн үр дүн 48.5 хувь байна.

Тэргүүлэх чиглэлийг бодлогоор нь авч үзвэл:

- **Эдийн засгийн бодлогын** тэргүүлэх чиглэлийн үр дүнг үнэлэх “Эдийн засгийн өсөлт” шалгуур үзүүлэлтийн статистик мэдээлэл тайлант хугацаанаас хоцрогдолтой гарахаар байгаа тул үр дүнг тооцох боломжгүй байна.

- **Бүсчилсэн хөгжлийн бодлогын** тэргүүлэх чиглэлийн үр дүнг “Хотын хөгжлийн индекс” шалгуур үзүүлэлтээр тооцоход 45.45 хувьтай дүгнэгдсэн.

Шинжилгээ: Тэргүүлэх чиглэлийн үр дүнг “Хотын хөгжлийн индекс”, “Аймгуудын өрсөлдөх чадварын индекс”, шалгуур үзүүлэлтээр тооцохоор төлөвлөсөн боловч Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвөөс “Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж” үзүүлэлтийг 2023 оноос хойш тооцож гаргаагүй байна.

Уг тэргүүлэх чиглэл 45.45 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь “Хотын хөгжлийн индекс” шалгуур үзүүлэлтийн “Боловсрол” бүлгийн индекс 0.0282 пунктээр, “Хувь хүний аюулгүй байдал” бүлгийн индекс 0.0192 пунктээр тус тус буурсантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл сургуулийн өмнөх боловсрол болон ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт хангалтгүй, өдөрт 2 ээлжээр хичээллэдэг ерөнхий боловсролын сургуулийн тоо буураагүйтэй холбоотой байна.

- **Хүний хөгжлийн бодлогын** тэргүүлэх чиглэлийн үр дүнг “Хүний хөгжлийн индекс” шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөж, 193 улсаас зэрэглэлээр 95 дугаарт орохоор зорьсон байна.

Шинжилгээ: Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөрөөс гаргадаг “Human Development Report 2025” тайланд Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 0.747 байна. Хүний хөгжлийн индекс 2024 онд (2022 суурь) 0.741 байсан бол 2025 онд (2023 суурь) 0.747 болж өссөн нь хүний хөгжилд чиглэсэн бодлогын үр дүн “ээрэг” гарсан хэдий ч дэлхийн зэрэглэлээр 104 дүгээрт жагссан байна. Эрэмбэ ухарсан шалтгаан нь чанартай боловсрол болон Монгол хүний дундаж наслалтаас шалтгаалсан байна.

Монгол хүний дундаж наслалт 72.7-оос 71.7 нас болж буурсан нь нас баралтын түвшин, архаг өвчлөл, осол гэмтэл, амьдралын хэв маягтай холбоотой эрсдэлүүд бодлогын түвшинд бүрэн шийдэгдээгүй байгааг харуулж байна. Боловсролын салбарын хувьд, насанд хүрсэн хүний дундаж суралцсан жил хэвээр хадгалагдсан боловч суралцахаар хүлээгдэж байгаа жилийн үзүүлэлт буурсан нь боловсролын хүртээмж, ялангуяа ирээдүйд хүний капиталд сөрөг эрсдэл үүсэх магадлалтайг харуулж байна.

• **Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын тэргүүлэх чиглэлийн үр дүнг** “Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж”, “Авлигын индекс” шалгуур үзүүлэлтүүдээр үнэлэхээр төлөвлөсөн ба бодлогын үр дүн “100” хувь буюу “үр дүн гарсан” дүгнэгдсэн.

Шинжилгээ: Дэлхийн банкнаас эрхлэн гаргадаг Засаглалын үзүүлэлтүүд 2024 онд шинэчлэгдэн зарлагдаад байна. Тус үзүүлэлтээр нийт 213 улсыг хамруулан үнэлснээс Монгол Улс 2024 онд -0.08 оноогоор 111 дүгээр байрт эрэмбэлэгдсэн нь 2023 оны суурь түвшин -0.15 онооноос 0.07 оноогоор өсөж, 2 байраар ахисан байна.

“Транспэрэнси Интернэшнл” байгууллагаас 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр 2024 оны Авлигын төсөөллийн индексийг нийтэлсэн бөгөөд Монгол Улс нь 180 орноос 114 дүгээр байрт орж, эрэмбийн хувьд 7 байраар урагшилсан байна.

Хүснэгт 1. Тэргүүлэх чиглэлийн үр дүн, шалгуур үзүүлэлтээр

Д/д	Бодлого	Үзүүлэлт	Суурь он түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Гүйцэтгэл ийн хувь	Мэдээллийн эх сурвалж, хугацаа	Хариуцах байгууллага
1	Эдийн засгийн бодлого	Эдийн засгийн өсөлт, хувь	2024 он 6	8		-	2026.06, ҮСХ	ЭЗХЯ
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	Аймгуудын өрсөлдөх чадварын индексийн дундаж, хувь	2023 он 66.5	70		45.45	Тодорхойгүй , Эдийн засгийн бодлого,өрсөлдөх чадварын судалгааны төв	ЭЗХЯ
3		Хотын хөгжлийн индекс, оноо	2021 он 0.46	0.57	2025 он 0.51		2026.06, НЗДТГ	НЗДТГ
4	Хүний хөгжлийн бодлого	Хүний хөгжлийн индекс, эрэмбэ	2022 он 96	95	2025 он 104	0	2026.05, НҮБ	ЭЗХЯ
5	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дундаж, эрэмбэ	2022 он 113/180	112/180	2024 он 111	100	2026.11, Дэлхийн банк	ЗГХЭГ
6		Авлигын индекс, эрэмбэ	2023 он 121/170	118/170	2024 он 114		2026.02, “Транспэрэнси Интернэшнл ”	МУҮАБЗ
Дундаж						48.5		

Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”

“Хотын хөгжлийн индекс” үзүүлэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар урьдчилсан гүйцэтгэлээр гаргасан бол Үндэсний статистикийн хорооноос “Эдийн засгийн өсөлт”-ийг 2026 оны 6 дугаар сард, Дэлхийн банк “Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт”-ийг 2026 оны 11 дүгээр сард, “Транспэрэнси Интернэшнл” “Авлигын индекс”-ийг 2026 оны 02 дугаар сард тооцон гаргахаар байна. Иймд тус үзүүлэлтүүдийг 2024 оны үзүүлэлтээр, “Хүний хөгжлийн индекс”-ийг НҮБ-аас 2025 оны 02 дугаар сард зарласан үзүүлэлтэд үндэслэв.

Тэргүүлэх чиглэлийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн статистик мэдээлэл тайлант хугацаанаас хоцрогдолтой гарч байгаа нь бодлогын баримт бичгийн тухайн жилийн

гүйцэтгэлийг бүрэн үнэлэх боломжгүйд хүргэж, зарим хүрсэн түвшин өмнөх оны статистик мэдээллээр дүгнэгдэж байна.

3.1.2.Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн 29 үр дүнг 47 шалгуур үзүүлэлтийн дагуу тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэхэд гүйцэтгэл **59.7 хувь** байна.

Хүснэгт 2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, бодлогоор

Бодлого	ТЕЗ-ийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж хувь
Нэг. Эдийн засгийн бодлого	12	47
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	3	33.3
Гурав. Хүний хөгжлийн бодлого	8	85
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	6	73.3
Нийт	29	59.7

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Хүний хөгжлийн бодлогын зорилго нь 85-аас дээш, Эдийн засгийн бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлого, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын зорилго нь тус тус 85-аас доош хувьтай дүгнэгдэж байна.

3.1.2.1.Эдийн засгийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 12 үр дүнг 16 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл дунджаар 47.0 хувь байна.

Хүснэгт 3. Эдийн засгийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, шалгуур үзүүлэлт, төсөл, арга хэмжээгээр

ТЕЗ-ийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүн, шалгуур үзүүлэлтээр		ТЕЗ-ийн үр дүн, арга хэмжээгээр		Хариуцах байгууллага
	Тоо	Гүйцэтгэл, хувь	Тоо	Гүйцэтгэл, хувь	
1.1. Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1	Үзүүлэлт гараагүй	6	79.5	ЭЗХЯ, ШСАА (Өрсөлдөөний асуудал эрхэлсэн), СЯ, ЗГХЭГ
1.2. Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	1	0.0	13	66.7	ХХААХҮЯ, СЯ, НЗДТГ
1.3. Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүний дотоод хангамжийг нэмэгдүүлнэ.	4	36.06	5	57.6	ХХААХҮЯ, ШСАА (Онцгой байдлын асуудал эрхэлсэн)
1.4. Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1	100.0	18	41.5	АҮЭБЯ
1.5. Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	100.0	27	44.5	ЗТЯ, СЯ, НЗДТГ
1.6. Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	1	100.0	8	41.9	Сангийн яам

1.7. Эрчим хүчний дотоодын хэрэгцээг хангана.	1	15.1	27	46.9	ЭХЯ, ХББОСЯ
1.8. Дөрвөн улирлын аялал жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээг хөгжүүлнэ.	2	28.7	30	52.6	ССАЖЗЯ, ЗТЯ
1.9. Хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үйл ажиллагаа эрхлэх таатай орчныг бүрдүүлнэ.	1	42.9	4	63.8	СЗХ, Монгол банк
1.10. Байгаль орчинд ээлтэй хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1	Үзүүлэлт гараагүй	3	56.7	БОУАӨЯ, СЗХ
1.11. Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.	1	Үзүүлэлт гараагүй	13	76.0	БОУАӨЯ, ХХААХҮЯ, СЯ
1.12. Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ.	1	0.0	13	71.3	ЭЗХЯ
Дундаж	16	47.0	167	54.5	

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагч 12 үр дүнд хүрэхээр зорьж, 3 үр дүн 100 хувь буюу "үр дүн гарсан", 6 үр дүн 85-аас доош хувьтай дүгнэгдэж, 3 үр дүнг дүгнэх шалгуур үзүүлэлт нь тайлант хугацаанаас хоцрогдолтой буюу 2-3 жил тутам гарах үзүүлэлтээр төлөвлөснөөс шалтгаалан үр дүнг тооцох боломжгүй байна.

Хүснэгт 4. Эдийн засгийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлт, давтамжаар

ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл цуглуулах эх сурвалж	Мэдээлэл цуглуулах давтамж, хариуцах байгууллага
1.1	Бизнесийн орчны судалгааны ерөнхий үзүүлэлтийн үнэлгээ	Монголын бизнесийн орчны судалгааны тайлан.	Суурь он 2023, 3 жил тутам, МХАҮТ
1.10.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс: Уур амьсгалын өөрчлөлтийн үзүүлэлт	Иелийн Их сургуулийн судалгаа.	Суурь он 2024, 2 жил тутам, БОУАӨЯ
1.11.	Байгаль орчны гүйцэтгэлийн индекс: Экосистемийн үзүүлэлт		

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Шинжилгээ: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны "Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ." гэх, Сангийн яамны "Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ." гэх үр дүн, Зам, тээврийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн "Ачаа тээвэрлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ." гэх үр дүнгүүд шалгуур үзүүлэлтийн дагуу 100 хувь буюу "Үр дүн гарсан" дүгнэгдсэн.

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам "Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ." гэх үр дүнгийн хүрээнд сайдын 2025 оны А/19 дүгээр тушаалаар "Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авах журам"-ыг шинэчлэн баталж, тус журмын гүйцэтгэлийн хүрээнд 37 уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын ашиглалтад хүлээн авсан.

Түүнчлэн ашигт малтмалын үйлдвэрлэлийг голлох төрлөөр нь авч үзвэл алтны хувьд 4.9 сая.м³ элс, 9.6 сая.тн хүдэр олборлож 16.3 тн металлыг Монголбанкны худалдан авалтын гэрээний дагуу тушаасан, зэсийн хувьд 92.51 сая.тн хүдэр олборлож 2.3 сая.тн зэсийн баяжмал, төмрийн хувьд 11.52 сая.тн хүдэр олборлож 8.8 сая.тн төмрийн баяжмал, цайрын хувьд 429.35 мян.тн хүдэр олборлож 149.2 мян.тн цайрын баяжмал, хайлуур

жоншны хувьд 840.74 сая.тн хүдэр олборлож 1.8 сая.тн хайлуур жоншны баяжмалыг тус тус үйлдвэрлэж, баяжуулсан байна.

Сангийн яам Замын-Үүд, Хавирга, Бичигт, Булган, Гашуунсухайт, Ханги, Шивээхүрэн зэрэг хилийн боомтуудад Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалт, БНХАУ-ын буцалтгүй тусламжаар зорчигч болон ачаа тээврийн гарцыг нэмэгдүүлж, ухаалаг гарцын байгууламжийг суурилуулж, AGV буюу автомат удирдлагатай тээврийг нэвтрүүлсний үр дүнд тайлант онд Монгол Улс 90.0 сая.тонн нүүрс экспортлоод байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.5 хувиар өссөн байна.

Харин Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.” гэх зорилт 85 хувиас доош үнэлэгдсэн нь шалгуур үзүүлэлтийн статистик мэдээлэл тайлант хугацаанаас хоцрогдолтой гарахаар байгаатай холбоотой байна. Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх шалгуур үзүүлэлт нь 2026 оны хагас жилээр гарахаар байна.

Хөнгөн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортыг 2023 оны суурь түвшин буюу 484.8 сая ам.доллараас 533.3 сая ам.долларт хүргэхээр зорьсон боловч 2025 оны эхний 11 сарын байдлаар 358.7 сая ам. доллар байна. Энэ нь 2024 оны мөн үеийн гүйцэтгэлийн түвшинтэй харьцуулахад 11.8 хувиар бага байна. 2024 оны эхний 11 дүгээр сард 625.5 тонн самнасан ноолуурыг 60.0 сая ам.доллараар экспортолсон бол 2025 оны эхний 11 сарын байдлаар 3509.9 тонн самнасан ноолуурыг 288.8 сая ам.доллараар экспортолсон нь биет хэмжээгээр 5.6 дахин, мөнгөн дүнгээр 4.8 дахин, хувцас болон бусад зүйлсийн экспорт 34 хувиар тус тус өссөн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны “Шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлнэ.” гэх зорилт 85 хувиас доош үнэлэгдсэн. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас 2025 онд гаргасан Дэлхийн инновацын индексийн үзүүлэлтээр Монгол улс 139 орноос 78 дугаарт эрэмбэлэгдсэн байна.

3.1.2.2.Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 3 үр дүнг 3 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл дунджаар 33.3 хувьтай байна.

Хүснэгт 5. Бүсчилсэн хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, шалгуур үзүүлэлт, төсөл, арга хэмжээгээр

ТЕЗ-ийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүн, шалгуур үзүүлэлтээр		ТЕЗ-ийн үр дүн, арга хэмжээгээр		Хариуцах байгууллага
	Тоо	Гүйцэтгэл, хувь	Тоо	Гүйцэтгэл, хувь	
2.1. Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлнэ.	1	100	16	100	ЭХЯ, ШСАА (Өрсөлдөөний эрхэлсэн), ЭМЯ, НЗДТГ, ХББОСЯ, АҮЭБЯ, ЭЗХЯ, ЗТЯ
2.2. Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулна.	1	0	7	0	НЗДТГ
2.3. Төвлөрлийг сааруулж, агаарын бохирдлыг бууруулна.	1	0	30	30.0	ЗГХЭГ, Монгол банк, ХББОСЯ, ЭХЯ, БОУАӨЯ, НЗДТГ,
Нийт	3	33.3	53	63.6	

Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”

Шинжилгээ: 8 төсвийн ерөнхийлөн захирагчийн “Орон нутгийн эдийн засгийн чадамжийг нэмэгдүүлнэ.” гэх үр дүнг улсын төсвөөс санхүүжилт авдаггүй аймгийн тоогоор үнэлэхээр төлөвлөж, уг үзүүлэлтийг 2023 оны суурь үзүүлэлт буюу 6 аймгаас 8-д хүргэхээр зорьсон байна. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлд 12 аймаг улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахаар заасан тул улсын төсвөөс санхүүжилт авдаггүй аймгийн тоо 9-д хүрсэн байна. Тайлант онд бүсчилсэн хөгжлийг түлхүү дэмжих бодлого баримталсан бөгөөд аж үйлдвэр, уул уурхай давамгайлсан, тээвэр, худалдаа, үйлчилгээ хөгжсөн аймгуудад санхүүгийн дэмжлэгийг багасгаж, харин хүн амын нягтаршил, өөрийн орлого багатай аймгуудад илүү чиглүүлснээр зорилтот түвшинд хүрсэн байна.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2025 онд “Улаанбаатар хотын зорчих дэд бүтцийн хүртээмжийг сайжруулах” гэх зорилтын хүрээнд нийслэлийн замын хөдөлгөөний дундаж хурдыг 2023 оны суурь түвшин буюу 12км/ц-аас 16 км/цаг болгох зорилт тавьж ажилласан хэдий ч зорилтот түвшинд хүрээгүй, дундаж хурд 11км/цаг байна.

Шинжилгээ: Нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах зорилт нь үр дүнд хүрээгүй байна.

Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний урсгалд ажлын өдөр нийт 58 байршилд буюу 28 уулзвар, 4 тойрог уулзвар, 26 замын хэсэгт, ажлын болон амралтын өдрийн өглөөний оргил цагт (07:00-08:00), өдрийн оргил цагт (13:00-14:00), оройн оргил цагт (17:00-18:00) судалгаа хийсэн байна. Судалгааны дүнгээр замын хөдөлгөөний дундаж хурд оройн оргил ачааллын үед ажлын өдрүүдэд 5.57 км/цаг, амралтын өдрүүдэд 8.19 км/цаг, өглөөний оргил цагт ажлын өдрүүдэд 11.07 км/цаг, амралтын өдрүүдэд 16.27 км/цаг гэсэн үр дүн гарсан байна.

Нийслэлд дунд болон урт хугацааны шинжтэй дэд бүтцийн томоохон төслүүдийг (метро, дүүжин зам, BRT зэрэг) хэрэгжүүлэх бэлтгэл ажил, барилга угсралтын ажлууд эрчимтэй үргэлжилж байгаа боловч бодит үр дүн хараахан гарч эхлээгүй байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас гаргасан /<http://agaar.mn/article-view/> Улаанбаатар хотын хүйтний улирлын агаарын чанарын төлөв байдал /2025 оны 12 дугаар сар/-ын мэдээлэлд үндэслэв. Улаанбаатар хотын агаар бохирдуулах бодисын 2025 оны 12 дугаар сарын дундаж агууламж 77 мкг/м³ байна. Үүнийг өмнөх оны мөн үе буюу 2024 оны 12 дугаар сарын дундаж (95 мкг/м³) агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 18 мкг/м³-ээр буурсан хэдий ч, энэ нь төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй, PM2.5 тоосонцор суурь түвшин буюу 2023 оны дунджаас 36 мкг/м³ их байна. Эх сурвалж: <http://agaar.mn/article-view/1455>

3.1.2.3. Хүний хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 8 үр дүнг 22 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл дунджаар 85 хувь буюу “үр дүн гарсан” байна.

Хүснэгт 6. Хүний хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, шалгуур үзүүлэлт, төсөл, арга хэмжээгээр

ТЭЗ-ийн үр дүн	ТЭЗ-ийн үр дүн, хувь		ТЭЗ-ийн үр дүн, арга хэмжээгээр		Хариуцах байгууллага
	Тоо	Гүйцэтгэл, хувь	Тоо	Гүйцэтгэл, хувь	
3.1. Өвчлөл, нас баралтыг бууруулна.	1	100.0	21	56.4	ЭМЯ, ССАЖЗЯ
3.2. Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна.	15	77	17	88.0	Боловсролын яам

3.3. Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	1	0	5	100	ГБХНХЯ
3.4. Нийгмийн баталгааг сайжруулна.	1	100.0	3	100	ГБХНХЯ, ТАЗ, ЗГХЭГ
3.5. Зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.	1	100.0	5	100	ГБХНХЯ, ХХААХҮ
3.6. Соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	100.0	4	0	ССАЖЗЯ
3.7. Түүх, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	1	100.0	3	100	ССАЖЗЯ
3.8. Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.	1	100.0	-	-	ССАЖЗЯ
Нийт	22	85	58	74.3	

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Хүний хөгжлийн бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 8 үр дүнд хүрэхээр зорьсон боловч 6 үр дүн 85-аас дээш, 2 үр дүн 85-аас доош хувьтай дүгнэгдсэн.

Боловсролын яамны дангаар хариуцах "Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулна." үр дүнг 15 шалгуур үзүүлэлтээр дүгнэхээр төлөвлөсөн ба сургуульд бэлтгэгдсэн байдлын болон чанарын үнэлгээ хийх төсөв батлагдаагүйгээс 5 шалгуур үзүүлэлтийн тоон мэдээг гаргах боломжгүй байна.

Хүснэгт 7. Хүний хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлт, давтамжаар

ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл цуглуулах эх сурвалж	Мэдээлэл цуглуулах давтамж, хариуцах байгууллага
3.2.	1.Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ	Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ, Боловсролын яам	Суурь түвшин-2023, 1 жил тутам, Боловсролын яам
3.2.	4.Бага боловсролын чанарын үнэлгээний дундаж	Чанарын үнэлгээ, Боловсролын яам	Суурь түвшин-2022, 3 жил тутам Боловсролын яам
3.2.	5.Суурь боловсролын чанарын үнэлгээний дундаж	Чанарын үнэлгээ, Боловсролын яам	Суурь түвшин-2022, 3 жил тутам Боловсролын яам
3.2.	6.Унших суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж /монгол хэлний шалгалтын гүйцэтгэлийн дундаж/	Чанарын үнэлгээ, Боловсролын яам	Суурь түвшин-2021, 3 жил тутам Боловсролын яам
3.2.	7. Математикийн хичээлээр суурь чадвар эзэмшсэн 9 дүгээр ангийн суралцагчдын гүйцэтгэлийн дундаж	Чанарын үнэлгээ, Боловсролын яам	Суурь түвшин-2021, 3 жил тутам Боловсролын яам

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам "Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ." гэх үр дүнд хүрэхээр зорьж, уг зорилтын гүйцэтгэлийг "Хүүхдийн эрхийн индекс" шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн байна. Эразмус эдийн засгийн сургууль, Олон Улсын нийгмийн судлалын хүрээлэн, Хүүхдийн эрхийн сантай хамтран гаргасан 2025 оны судалгаагаар Монгол Улс хүүхдийн эрхийн индексээрээ 194 орноос 0.709 оноогоор 86 дугаар байранд эрэмбэлэгдэж байна. Тус үзүүлэлтийг амьдрах орчин, эрүүл мэнд, боловсрол, хүүхэд хамгаалал, хүрээлэн

байгаа орчны нөхцөл гэсэн үндсэн таван үзүүлэлтээр хэмждэг бөгөөд эрүүл мэнд болон хүрээлэн буй орчны үзүүлэлт хамгийн бага байна.

Хүний хөгжлийн бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн “Соёлын салбарыг эдийн засгийн эргэлтэд оруулна.” гэх үр дүнг соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар хэмжихээр төлөвлөж, 2023 оны суурь түвшин 0.4 хувиас 0.8 хувьд хүргэхээр зорьж, 1.4 хувьд хүрсэн гэж тайлагнажээ.

Тайлагнагч байгууллага нотлох баримтаар 2021 оны Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгааг ирүүлсэн. Уг судалгаагаар соёлын бүтээлч үйлдвэрлэлийн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2020 онд 1.3 хувь буюу 481.4 тэрбум төгрөг байна.

Үндэсний статистикийн хорооны 1212.mn албан ёсны цахим хуудаст байршуулсан нээлттэй мэдээллээр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2025 оны эхний 3 улирлын байдлаар 60.1 их наяд байгааг нотлох баримтаар ирүүлсэн 2021 оны Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгааны дүнтэй харьцуулахад 0.8% байна.

Түүнчлэн Үндэсний статистикийн хорооны 1212.mn албан ёсны цахим хуудаст байршуулсан нээлттэй мэдээллээр Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны байдлаар 70.4 их наяд байжээ. Нотлох баримтаар ирүүлсэн 2021 оны Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн суурь судалгааны дүнтэй харьцуулахад 0.68 хувь байна.

Иймд хөгжлийн бодлогын баримт бичигт “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь”-ийн суурь түвшинг төлөвлөхдөө ямар нотлох баримтад үндэслэсэн нь тодорхойгүй байна.

3.1.2.4. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 6 үр дүнг 6 шалгуур үзүүлэлтээр үнэлэхээр төлөвлөсөн бөгөөд гүйцэтгэл дунджаар 73.3 хувьтай байна.

Хүснэгт 8. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн, шалгуур үзүүлэлт, төсөл, арга хэмжээгээр

ТЕЗ-ийн үр дүн	ТЕЗ-ийн үр дүн, шалгуураар		ТЕЗ-ийн үр дүн, арга хэмжээгээр		Хариуцах байгууллага
	Тоо	Гүйцэтгэл, хувь	Тоо	Гүйцэтгэл, хувь	
4.1. Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	1	0.00	15	100	ЦХИХХЯ, ЕС, ЭЗХЯ, ХЗДХЯ,
4.2. Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.	1	-	3	75.0	ХЗДХЯ
4.3. Авлигын гэмт хэргийг бууруулна.	1	100	2	0	АТГ
4.4. Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлнэ.	1	100	4	100	БХЯ
4.5. Хилийн аюулгүй байдлыг хангана.	1	93.0	3	100	ХЗДХЯ
4.6. Орчны аюулгүй байдлыг хангана.	1	-	23	100	ШСАА (Онцгой байдлын асуудал эрхэлсэн), ХББОСЯ, БОУАӨЯ, НЗДТГ, ШЕЗ, ХЗДХЯ, ГХЯ
Дундаж	6	73.3	50	64.4	

Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”

Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын хүрээнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 6 үр дүнд хүрэхээр зорьж, 3 үр дүн 85-аас дээш буюу “үр дүн гарсан”, 1 үр дүн 85-аас доош хувьтай дүгнэгдэж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлөөс “Шүүхэд итгэх иргэдийн итгэл санал асуулгын судалгаа”-ны дүнг 5 жил тутам гаргахаар төлөвлөгөөнд тусгасан хэдий ч 2019 оноос хойш судалгаа огт хийгдээгүй байна. Мэдээллийн эх сурвалж гараагүй тул тус “Шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ” гэсэн үр дүнг зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байна.

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/135 дугаар тушаалаар Байгаль орчны статистик үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлалыг баталсан. Энэхүү аргачлалын дагуу Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны салбарын хүрээнд 19 маягаар Байгаль орчны статистик мэдээллийг гаргадаг. Мэдээ тайлан гаргах цаглаврын хувьд 2025 оны статистик мэдээллийг 2026 оны 3 дугаар сарын 20-ны дотор гаргах ёстой. Харин 2024 оны статистик мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 25-нд Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн. Мэдээллийн эх сурвалж гараагүй тул тус үр дүнг зорилтот түвшинд хүрсэн эсэхэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжгүй байна.

Хүснэгт 9. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогын төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлт, давтамжаар

ТЕЗ-ийн үр дүн	Шалгуур үзүүлэлт	Мэдээлэл цуглуулах эх сурвалж	Мэдээлэл цуглуулах давтамж, хариуцах байгууллага
4.2	Шүүхэд итгэх иргэдийн итгэл	Судалгааны тайлан, ШЕЗ	Суурь 2019 он, 5 жил тутам, ХЭҮК
4.6	Орчны эрсдэлийн түвшин	Статистик мэдээ, БОУАӨЯ	Тооцох, ХББОСЯ, БОУАӨЯ

Эх сурвалж: “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан”

Шинжилгээ: Авлигатай тэмцэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яамд авлигын гэмт хэргийг бууруулах, хилийн аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэх зорилт тавин ажилласан бөгөөд хилийн цэргийн анги, салбарын барилга, инженер техникийн байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, зэвсэг техникийн хангамжийг сайжруулах, цэргийн албан хаагчдын болон цэргийн үүрэгтний ур чадварыг дээшлүүлэх, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдээлэл хүргэх зэрэг олон чиглэлээр тодорхой үр дүн гарсан арга хэмжээ авч ажилласнаар төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 100 хувь буюу “үр дүн гарсан” гэж дүгнэгдсэн.

Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологи, инновац, хиймэл оюун ухааны салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтыг судалгаа хөгжүүлэлтийн ажилд зарцуулах төсвийн зардлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар дүгнэхээр төлөвлөсөн боловч зорилтот түвшинд хүрээгүй нь төсвийн тодотголоор салбарын эрдэм шинжилгээ, судалгааны төсвийг 53.1 хувиар буцаан татсантай холбоотой байна.

3.1.3. Хөтөлбөрийн үр дүн

Монгол Улсын 2025 онд баримтлах бодлогын хөтөлбөрийн 63 үр дүн урьдчилан тодорхойлсон 91 шалгуур үзүүлэлтийн дагуу зорилтод болон хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэхэд гүйцэтгэл 57.1 хувьтай байна.

Хүснэгт 10. Хөтөлбөрийн үр дүн, бодлогоор

Бодлого	Хөтөлбөрийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүнгийн дундаж хувь
Эдийн засгийн бодлого	30	57.3

Бүсчилсэн хөгжлийн бодлого	6	35.3
Хүний хөгжлийн бодлого	15	64.1
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	12	58.8
Нийт	63	57.1

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан хөтөлбөрийн 63 үр дүнг бодлогоор авч үзэхэд, Эдийн засгийн бодлогод хамаарах 30 үр дүн дунджаар 57.3 хувь, Бүсчилсэн хөгжлийн бодлогод хамаарах 6 үр дүн дунджаар 35.3 хувь, Хүний хөгжлийн бодлогод хамаарах 15 үр дүн дунджаар 64.1 хувь, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлогод хамаарах 12 үр дүн дунджаар 58.8 хувьтай байна.

Хүснэгт 11.Хөтөлбөрийн үр дүн, гүйцэтгэлийн хувь

Бодлого	Нийт	Төсөл, арга хэмжээ	
		85 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй	0-85 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй
Эдийн засгийн бодлого	30	12	18
Бүсчилсэн хөгжлийн бодлого	6	1	5
Хүний хөгжлийн бодлого	15	6	9
Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	12	4	8
Нийт	63	23	40
Хувь		36.5	63.5

Хөтөлбөрийн үр дүнг гүйцэтгэлийн хувиар авч үзвэл 23 төсөл, арга хэмжээ буюу 36.5 хувь нь 85-аас дээш хувьтай, 40 төсөл, арга хэмжээ буюу 63.5 хувь нь 85-аас доош хувьтай дүгнэгдэж байна.

3.1.4.Төсөл, арга хэмжээний үр дүн

Төлөвлөгөөнд тусгасан 328 төсөл, арга хэмжээнээс агуулгын хувьд давхардаж байгаа 2 арга хэмжээг хасаж, хяналт-шинжилгээ, үнэлгээнд 326 төсөл, арга хэмжээг хамруулав.

Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан 326 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл дунджаар **61.0** хувь байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан нийт 326 төсөл, арга хэмжээний 49.1 хувь буюу 161 төсөл, арга хэмжээ 85 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй, 165 төсөл, арга хэмжээ буюу 50.3 хувь нь 85-аас доош хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

Хүснэгт 12.Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

Бодлого	Төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэл, хувь	Төсөл, арга хэмжээ	
			85 ба түүнээс дээш хувийн гүйцэтгэлтэй	0-85 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй
Нэг.Эдийн засгийн бодлого	167	63.6	71	96
Хоёр.Бүсчилсэн хөгжлийн бодлого	51	74.3	27	24
Гурав.Хүний хөгжлийн бодлого	58	64.4	37	21
Дөрөв.Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	50	54.5	26	24
Нийт дүн	326	61.0	161	165
Хувь			49.1	50.3

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Нийт төсөл, арга хэмжээний 50.3 хувь буюу 165 төсөл, арга хэмжээ 85 хувиас доош хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн нь дараах шалтгаантай байна. Тухайлбал,

- Улсын хөгжлийн төлөвлөгөөнд санхүүгийн эх үүсвэр тусгагдаагүй, улсын төсөвт санал хүргүүлсэн ч батлагдаагүй, төсвийн тодотголоор төсөв хасагдсан “Өмнөговь аймгийн Гурвантэс суманд “Нийтийн зориулалтын тээвэр логистик, агуулахын терминал” барих”, “Налайх-Тэрэлж чиглэлийн 37 км авто замыг 4 эгнээ болгон өргөтгөх” зэрэг 35 төсөл, арга хэмжээ;

- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилсан шатны бэлтгэл ажлууд буюу судалгаа шинжилгээ хийх, ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах, хянах “1.8.2.2. “Мөрөн” нисэх буудлыг 4С ангиллын болгон хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлэх”, “2.3.2.3. Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээний бүтээн байгуулалтыг эхлүүлэх” зэрэг 21 төсөл, арга хэмжээ;

- Тендер шалгаруулалт, гэрээ, хэлэлцээр хийх ажил удаашралтай “1.5.1.7. Ховд аймгийн Булган сумын Ярантын боомтын нүүрсний экспортын терминалыг барих ажлыг эхлүүлэх”, “1.7.3.9. Чойр-Сайншанд 230 км урттай 220 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих” зэрэг 18 төсөл, арга хэмжээ;

- Эмчилгээний шинэ арга, технологи нутагшуулах цаг хугацаа шаардсан, удаашралтай “3.1.2.8. Монгол Улсад оношлогдох, эмчлэгдэх боломжгүй өвчний чиглэлээр технологи нэвтрүүлэх” гэх 1 төсөл арга хэмжээ;

- Инженерийн шугам сүлжээний трасс давхардсан, үйлдвэр, техник тоног төхөөрөмж эвдэрсэн, бараа бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх, тоног төхөөрөмж угсрах ажил удаашралтай явагдаж байгаа “1.2.3.3. Төвийн бүсийн хөнгөн аж үйлдвэрийн үйлдвэр технологийн паркийн төслийг хэрэгжүүлэх /Дарханы арьс ширний цогцолбор болон бусад/”, “4.6.1.4. Даралтын хэмжлийн эталон тоног төхөөрөмжийн нарийвчлалыг олон улсын жишгийн дагуу нэмэгдүүлэх” зэрэг 50 төсөл, арга хэмжээ;


- Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой газар шийдэгдээгүй, мэдээллийн аюулгүй байдлын гадаад, дотоодын үнэлгээ хийлгэх гадаад хүчин зүйлээс шалтгаалан “3.2.2.3. Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол болон аутсорсингийн төвийг байгуулах төслийг хэрэгжүүлэх”, “4.6.3.2. Кибер аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлэх” зэрэг 6 төсөл арга хэмжээ;

- Хөрөнгө санхүү, техникийн болон бусад нөөцийг урьдчилан тооцоолоогүй тайлант хугацаанд хэрэгжих боломжгүй, шалгуур үзүүлэлт арга хэмжээтэй уялдаагүй тул урьдчилан тодорхойлсон шалгуурын дагуу хүрсэн түвшинг дүгнэх боломжгүй төлөвлөлтийн алдаатай “1.4.3.7. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах”, “1.4.3.4. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах” зэрэг 31 төсөл, арга хэмжээ;

- Шинээр барих станцын орчимд суурьшлын бүс төлөвлөгдөөгүй, 400 км-т 4С ангиллын ижил төрлийн нисэх буудлыг өргөжүүлэхээр төлөвлөсөн, эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж мега төслүүдийг ач холбогдол, үр нөлөөгөөр нь эрэмбэлснээс нэн шаардлагатай бус гэж үзсэн “1.7.3.15. Бөөрөлжүүтийн дулааны цахилгаан станцаас өргөх станцын хамт дулааны шугам барьж, суурьшлын бүсийг дулаанаар хангах төслийн бэлэн байдлыг хангах” “1.8.2.4. Дорнод аймгийн Буйр нуур орчимд 4С нисэх буудал байгуулах”, “2.3.2.2. Засгийн газрын “Нэг цэг”-ийн үйлчилгээний цогцолборын зураг төсөв, барилга угсралтын ажлыг эхлүүлэх” зэрэг 3 төсөл, арга хэмжээ байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллагаар авч үзвэл Батлан хамгаалах яам, Онцгой байдлын ерөнхий газар, Стандарт, хэмжил зүйн газрын хариуцсан арга хэмжээний дундаж 85 хувиас дээш буюу “үр дүн гарсан”, бусад байгууллагын дангаар хариуцан хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ 85 хувьд хүрэхгүй байна.

График 2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үндсэн хэрэгжүүлэгчээр



Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Хамтран хэрэгжүүлэх нийт 13 арга хэмжээний гүйцэтгэлийн дундаж 63.7 хувьтай дүгнэгдэж байна. Үүнээс арга хэмжээг хэрэгжүүлсэн байдлыг хэрэгжүүлэгч байгууллагаар нь авч үзвэл, Төрийн албаны зөвлөл-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын "3.4.2.2. Төрийн албаны "Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо", "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих" цахим системүүдийн интеграц, хөгжүүлэлтийг хийх", Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам-Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны хамтран хэрэгжүүлсэн "2.1.2.7. Хөвсгөл аймагт "Хөх баавгайн үүр" төслийг хэрэгжүүлэх" зэрэг 6 төсөл, арга хэмжээ 85-100 хувийн гүйцэтгэлтэй, Боловсролын яам-Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны хамтран хэрэгжүүлсэн "3.2.1.10. Халаалтын урсгал зардал өндөртэй сургууль, цэцэрлэгийн барилгад эрчим хүчний аудитын үнэлгээг үе шаттай хийлгэх, шинээр барих барилгыг пассив барилгын шаардлагад нийцүүлэх, эрчим хүчний хэмнэлттэй технологид шилжүүлэх, бэлтгэл хангах" зэрэг 7 төсөл, арга хэмжээ 85 хувиас доош хувийн гүйцэтгэлтэй тус тус дүгнэгдсэн.

3.1.5. Санхүүжилтийн гүйцэтгэл:

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан 326 төсөл, арга хэмжээнээс 287 төсөл, арга хэмжээг 19.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр, 39 төсөл, арга хэмжээг эх үүсвэр, мөнгөн дүн тодорхойгүй байдлаар тусгасан боловч Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд дээр дурдсан 326 төсөл, арга хэмжээнээс 107 төсөл, арга хэмжээний санхүүжилт тусгагдаагүй байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан төсөвт өртөгтэй 287 төсөл, арга хэмжээнээс Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын зардлын ангиллаас 77 төсөл, арга хэмжээг 1.0 их наяд төгрөгөөр

санхүүжүүлсэн талаарх мэдээллийг Сангийн яамнаас ирүүлсэн. Үүнээс гадна хяналт-шинжилгээ, үнэлгээний (new.unelgee.gov.mn) цахим системд тайлагнасан мэдээллээс үзэхэд 103 төсөл, арга хэмжээнд 4.4 их наяд төгрөгийг зарцуулсан талаар тайлагнасан байна.

2025 оны санхүүжилтийн гүйцэтгэлээс үзэхэд нийт 180 төсөл, арга хэмжээнд **5.4 их наяд** төгрөг зарцуулжээ.

Шинжилгээ: Дээрх нөхцөл байдлаас үзэхэд Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 180 төсөл, арга хэмжээг 9.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 5.4 их наяд төгрөгөөр санхүүжүүлсэн нь тус бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээ 0-85 хүртэлх хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдэх нэг үндэслэл болж байна.


Хүснэгт 13. Санхүүжилт, гүйцэтгэлээр

Бодлого	Төсөл, арга хэмжээ	Төлөвлөсөн төсөв	Гүйцэтгэл /сая.төгрөг/	Гүйцэтгэлийн хувь
Нэг. Эдийн засгийн бодлого	78	5,973,232.6	3,425,062.8	57.3
Хоёр. Бүсчилсэн хөгжлийн бодлого	29	1,029,092.5	491,971.85	47.8
Гурав. Хүний хөгжлийн бодлого	43	1,832,478.6	1,282,002.4	70.0
Дөрөв. Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	30	424,555.6	244,878.31	57.7
Нийт	180	9,259,359.3	5,443,915.42	58.8

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 287 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг эх үүсвэр тус бүрээр авч үзэхэд:


График 3. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт, эх үүсвэрээр



Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

"Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө"-ний 287 төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэлийг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр авч үзэхэд:

График 4. Монгол Улсын хөгжлийн төлөвлөгөөний санхүүжилт, байгууллагаар



Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

3.2. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд заасан зорилтын хэдэн хувьд хүрсэн, шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь 9 бодлогын хүрээнд 243 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд арга, хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг жил жилээр тодорхойлоогүй байгаа тул түүний хэдэн хувьд хүрснийг арга хэмжээ бүрээр харьцуулан шинжлэх боломжгүй байна.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан 243 төсөл, арга хэмжээтэй Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан 59 төсөл, арга хэмжээ буюу 24.3 хувь нь агуулгын хувьд нийцэж байна.

Хүснэгт 14. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн уялдаа

Д/д	Бодлого	ТЖҮЧ-ийн хүрээнд хэрэгжүүлбэл зохих арга хэмжээ	УХЖТ-ний ТЖҮЧ-тэй агуулгаараа уялдсан арга хэмжээ	Бодлогын баримт бичгүүдийн уялдаа /хувиар/
1	Эдийн засгийн бодлого	69	42	60.9
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	73	8	11.0
3	Хүний хөгжлийн бодлого	76	5	6.6
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	25	4	16.0

Нийт	243	59	24.3
------	-----	----	------

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

3.3. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэл нь Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээ шалгуур үзүүлэлт хангасан эсэхэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан, нийт 1396 төсөл, арга хэмжээнээс 2025 онд хэрэгжүүлж эхлэх 1234 төсөл, арга хэмжээтэй Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан, 160 арга хэмжээ буюу 13.0 хувь нь агуулгын хувьд нийцэж байна.

Хүснэгт 15. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан" төсөл, арга хэмжээний уялдаа

д/д	Бодлого	ЗГҮАХ-т тусгасан нийт арга хэмжээ	УХЖТ-ний ЗГҮАХ-т тусгасан уялдаатай арга хэмжээ	Бодлогын баримт бичгүүдийн уялдаа /хувиар/
1	Эдийн засгийн бодлого	484	77	15.9
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	147	24	16.3
3	Хүний хөгжлийн бодлого	282	33	11.7
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	321	26	8.1
Нийт		1234	160	13.0

Эх сурвалж: "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан"

Дээрх 160 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тухайн жилийн дүнгээр Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тухайн жилийн зорилтот түвшний 66.8 хувьд, өссөн дүнгээр буюу 2028 оны зорилтот түвшний 33.2 хувьд хүрсэн байна.

Хүснэгт 16. ЗГҮАХ-тэй уялдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, тухайн жилээр болон өссөн дүнгээр

Д/д	Бодлого	Уялдаатай төсөл, арга хэмжээ	Гүйцэтгэлийн хувь /Тухайн жил/	Гүйцэтгэлийн хувь /өссөн дүн/
1	Эдийн засгийн бодлого	77	56.7	30.7
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	24	68.9	31.4
3	Хүний хөгжлийн бодлого	33	69.6	36.1
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	26	72.1	36.4
Нийт дүн		160	66.8	33.6

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан 160 төсөл, арга хэмжээний 48.8 хувь буюу 78 нь "үр дүн гарсан", 9.4 хувь буюу 15 нь "үр дүн хүлээгдэж байгаа", 67 нь 59-аас доош хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 17. ЗГҮАХ-тэй уялдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, тухайн жилээр болон өссөн дүнгээр

Д/д	Бодлого	Арга хэмжээний тоо	Төсөл, арга хэмжээний тоо			
			85 ба түүнээс дээш хувийн хэрэгжилттэй	60-85 хүртэл хувийн хэрэгжилттэй	30-59 хувийн хэрэгжилттэй	0-29 хувийн хэрэгжилттэй
1	Эдийн засгийн бодлого	77	31	7	12	27
2	Бүсчилсэн хөгжлийн бодлого	24	12	3	5	4
3	Хүний хөгжлийн бодлого	33	18	4	4	7
4	Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого	26	17	1	2	6
Нийт		160	78	15	23	44
Хувь			48.8	9.4	14.4	27.5

Дөрөв. Дүгнэлт

4.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хүрээнд:

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр тэргүүлэх чиглэлийн үр дүн 48.5 хувь, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 59.7 хувь, хөтөлбөрийн үр дүн 57.1 хувь, нийт төсөл, арга хэмжээ дунджаар 61.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэргүүлэх чиглэлийн үр дүн 0.2 хувиар, хөтөлбөрийн үр дүн 0.14 хувиар, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 3.8 хувиар тус тус өссөн бол, төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.7 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан нь эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж төсөв танагдсантай холбоотой байна.

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан 326 төсөл, арга хэмжээний 50.3 хувь буюу 165 нь 85 хувиас доош гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байгаа нь төсөл, арга хэмжээг судалгаа, тооцоололд тулгуурлан үндэслэлтэй боловсруулаагүй, шаардлагатай төсөв, санхүүжилт батлагдаагүй, бэлтгэл, урьдчилсан шатны ажлын явц хангалтгүй, төлөвлөлтийн алдаатай зэргээс шалтгаалж байна.

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд 180 төсөл, арга хэмжээг 9.2 их наяд төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж, 5.4 их наяд төгрөгөөр санхүүжүүлсэн нь тус бодлогын баримт бичигт тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 85 хувиас доош хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдэх үндсэн шалтгаан болж байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан 326 төсөл, арга хэмжээнээс 39 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэр, мөнгөн дүнг төлөвлөгөөнд тусгаагүй, 107 төсөл, арга хэмжээг огт санхүүжүүлээгүй нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3 дахь заалт "улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх", мөн Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.8 дахь заалт "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх"-д заалт бүрэн хэрэгжихгүй байна.

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан 243 төсөл, арга хэмжээтэй Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан 59 төсөл, арга хэмжээ буюу 24.3 хувь нь агуулгын хувьд нийцэж байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан 2025 онд хэрэгжүүлэх нийт 1234 төсөл, арга хэмжээтэй Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан 160 арга хэмжээ буюу 13.0 хувь нь агуулгын хувьд нийцэж байна.

Дээрх 160 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тухайн жилийн дүнгээр Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл тухайн жилийн зорилтот түвшний 66.8 хувьд, өссөн дүнгээр буюу 2028 оны зорилтот түвшний 33.2 хувьд хүрсэн байна.

4.2. Эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

- Урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг хэмжихэд шаардлагатай Олон улсын байгууллагууд болон Үндэсний статистикийн хорооноос гардаг зарим статистик тоон мэдээ, мэдээлэл, судалгааны дүн (ядуурлын түвшин, дэлхийн инновацын индекс гэх мэт) тайлант он дууссаны дараа буюу өөрөөр хэлбэл 2025 оны

үзүүлэлт 2026 оны 2-6 дугаар сард гардаг.

Мөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурал жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийг хэлэлцэхээр, 17.3 дахь хэсэгт зааснаар Засгийн газар улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлангийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс 45 хоногийн өмнө буюу 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Улсын Их Хурлын Тамгын газар болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр зохицуулсан байна.

Дээрх хугацаанд хөгжлийн бодлогын баримт бичгийн үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай статистик тоон мэдээ, мэдээлэл, судалгааны дүн нэгтгэгдэж гараагүй байдаг байна.

- Худалдан авах ажиллагаа хийгдсэн хэдий ч гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлж, гэрээ эцэслэн байгуулах хуульд заасан хугацаанд, мөн худалдан авах ажиллагаатай холбоотой шүүхийн маргаан үргэлжлэх хугацаанд байх үед Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.1.1 дэх заалтын дагуу төсвийг хэмнэлтэд тооцон буцаан татсаны улмаас зарим төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. Иймд дээрх хуулийн холбогдох заалтыг худалдан авах ажиллагаа зарлагдсанаас хойш гэрээ байгуулах, шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдэх хүртэлх хугацаанд төсвийг буцаан татахгүй байхаар эрх зүйн зохицуулалт хийх шаардлагатай байна.

4.3.Бодлого төлөвлөлтийн хүрээнд:

- Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээ агуулгын хувьд Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан төсөл, арга хэмжээтэй 24.3 хувь, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан төсөл, арга хэмжээтэй 13.0 хувьтай уялдсан байна.

Гэсэн хэдий ч тэргүүлэх чиглэлийн болон төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн үзүүлэлтийг урт, дунд хугацааны бодлогын үр дүнтэй харьцуулахад шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, хэмжих нэгжийг ялгаатай тодорхойлсон нь төлөвлөлт “тогтвортой, тасралтгүй, залгамж чанартай байх зарчим” буюу хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, батлахдаа бодлогын тогтвортой байдлыг хадгалж, өмнө батлагдсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийн үр дүн, үнэлгээнд үндэслэх зарчмын шаардлагыг хангаагүй байна.

- Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээ нь хөрөнгө санхүү, техник технологи, шинжлэх ухаан, инновац, боловсон хүчин болон шаардлагатай бусад нөөцийг урьдчилан тооцоолсон төсөв, төсөөллийн дагуу тодорхойлоогүй нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нөөц, эх үүсвэрт үндэслэсэн байх, судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх, төлөвлөлтөд суурилсан төсөвлөлтийн зарчимд нийцээгүй байна.



Хавсралт. 1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан